



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/90/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Менежментийн захидал	11
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	14
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	20





**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

2020.02.24 № 1/221

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус салбарт мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

005020182

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын гол асуудал

Байгууллагын 2019 оны төсөвт анх 408497.4 мянган төгрөг баталж, аймгийн Засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 14742.5 мянган төгрөгийг нэмж тодотгон 423239.9 мянган төгрөг болсон байхад төсвөөс Төрийн сан 433239.9 мянган төгрөгийн эрх нээж олгож, батлагдсан төсвийг 10000.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг зөрчсөн байна.

Дээрх нь "Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх" гэсэн Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.


Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



2.1. Оршил

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн шууд захирагч Д.Оюундалай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 19-нөөс 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлж, аудит хийлгэх тухай албан бичгийг 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 137 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Мэргэжилтнээ дэмжиж, үйлчлүүлэгчээ хүндэлсэн, эмчилгээ, сувилгааны хариуцлагатай, ээлтэй, тэгш хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх”-д оршино.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь 2019 оны үйл ажиллагааны чиглэлийг “Цогц үйлчилгээг иргэдэд үзүүлэгч анхан шатны шилдэг эмнэлэг байх” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 44 оноотой үнэлэгдсэн тул мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзэж аудитыг томилогдсон аудитор гүйцэтгэлээ.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acoulous 4.10 программ хангамж ашигладаг байна.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 37 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 26 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Их” гэж үнэлэн, зардлын дүн тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 437358.7 мянган төгрөгөөс тооцон 8747.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар буюу 8747.8 мянган төгрөгөөр тооцсон бөгөөд төлөвлөлтийн шатанд тооцсон материаллаг байдлаас 0.6 мянган төгрөгөөр өссөн нь зардлыг бууруулж залруулга хийсэнтэй холбоотой байна.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3805.8 мянган төгрөгөөр буюу 0.99 хувиар буурсан нь үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-	-
АВЛАГА	503.95	535.86	31.91
УРЬДЧИЛГАА	112.50	400.00	287.50
БАРАА МАТЕРИАЛ	19,200.58	13,929.49	(5,271.09)
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	475,021.98	462,378.99	(12,642.99)
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГ ДЭЛ	(108,770.71)	(94,981.92)	13,788.79
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	386,068.30	382,262.42	(3,805.88)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	19.47	19.47
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	386,068.30	382,242.95	(3,825.35)
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	386,068.30	382,262.42	(3,805.88)

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 5271.0 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 13929.5 мянга, үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 12542.9 мянган төгрөгөөр буурч 462379.0 мянган төгрөг болсон нь тайлант онд сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019.05.21-ний өдрийн 13 тоот тогтоолоор 34480.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, байгууллагын даргын 2019.12.26-ний өдрийн А/75 тоот тушаалаар 11425.8 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл оны эцэст 382242.9 мянган төгрөг болж 3825.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээний зардалд зориулан аймгийн ИТХ-ын хуралдааны 2018 оны 14/03 тоот тогтоолоор 2019 оны төсвийг 408497.4 мянган төгрөг баталж, аймгийн Засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 14742.5 мянган төгрөгийг нэмж тодотгон 423239.9 мянган төгрөг болсон байхад төсвөөс 433239.9 мянган төгрөг олгож батлагдсан төсвийг 10000.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэсэнтэй нийцэхгүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт 5 арга хэмжээний зардалд зориулан тусгай зориулалтын шилжүүлгээр 379840.5 мянга, орон нутгийн төсвөөс 20529.3 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангаас 32655.1 мянган төгрөг авахаар

батлагдсанаас тусгай зориулалтын шилжүүлэг, орон нутгийн дэмжлэгийг бүрэн авч, харин Эрүүл мэндийн даатгалын сангаас 187.9 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан ба оны эцэст 7.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн нь тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлын хэмнэлт байна.

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвд өөрийн орлогын төлөвлөгөө өгөөгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт төсөв: Байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар “Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбоо”-ноос сорьц тээвэрлэлтийн зардалд 79.1 мянган төгрөг олгосныг тээврийн зардалд олгосон байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 37 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 26 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 37 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 9 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 28 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал /сая.төг/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	6	16.7	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	0.6	
3	Албан шаардлага өгсөн	1	0.00	
4	Сэхилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	8	17.30	

Аудитаар нийт 17311.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 585.3 мянган төгрөгийн 1 алдаанд төлбөрийн акт тогтоож, аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн Т.Гэрэлчулуунд хариуцлага тооцуулах албан шаардлагыг Эрүүл мэндийн газрын даргад хүргүүлж, 16725.8 мянга төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгснийг менежментийн захидалд тусгав.

Тайлант онд үйлдвэрчний эвлэлийн өглөгийг 19.4 мянга, цалингийн урьдчилгааг 236.7 мянган төгрөгөөр дутуу тусгасан байсныг санхүүгийн тайланд залруулав.

2.11.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.11.1.1. Зардлын данстай холбоотой асуудал

Байгууллагын даргын 2019.07.08-ны өдрийн Б/49 тоот тогтоолоор ажиллагсад цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлаас хоолны мөнгийг өдөрт 2000 төгрөгөөр тооцож, 772.0 мянган төгрөгийг олгохдоо нийгмийн даатгалын шимтгэл суутган тооцоогүй, нийгмийн даатгалын мэдээнд цалин түүнтэй адилтгах орлогыг мэдээлээгүй байна.

Ажилтанд олгосон 400.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй, авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2, 4 дэх хэсэгт заасан даатгуулагч болон ажил олгогч нь дор дурдсан хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

2.11.2.1. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

Байгууллагын 2019 оны төсөвт анх 408497.4 мянган төгрөг баталж, аймгийн засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 14742.5 мянган төгрөгийг нэмж тодотгон 423239.9 мянган төгрөг болсон байхад төсвөөс 433239.9 мянган төгрөг олгож, батлагдсан төсвийг 10000.0 мянган төгрөгөөр хэтрүүлсэн нь аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн Т.Гэрэлчулуун аймгийн Засаг даргын захирамжийг гаргуулахдаа дүнг буруу гаргасантай холбоотой байна.

Шийдвэрлэсэн: Аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн мэргэжилтэн Т.Гэрэлчулуунд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга С.Батцэцэгт хүргүүлэв.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн хуудаст оруулсан байдлыг шалгахад дараах байдалтай байна.

Жилээр мэдээлэх мэдээллээс дараа жилийн төсвийн төсөл, батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл зэрэг мэдээллийг сар бүр мэдээлэх орон тооны өөрчлөлтийг 11 сард хугацаа хоцроож мэдээлсэн байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9	2	-
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		



4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	70	26	
	Нийт	27	151	120	31	-

Шилэн дансны мэдээллийг хугацаандаа байршуулсан эсэхийг шалгахад оруулсан мэдээллийн 20.5 хувийг хугацаа хоцроож оруулсан байгааг цаашид анхаарч ажиллах, түүнд тавих төсвийн захирагчийн хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Байгууллагын 2018 оны санхүүгийн тайланд "Глобал капитал" ХХК гүйцэтгэж, зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Хязгаарлалттай” дүгнэлт

Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНБООУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын даргын 2019.01.02-ны өдрийн А/08 тоот тушаалаар байгууллагын орон тоог 28-аар баталсан байхад жилийн эцэст 29 орон тоо байгаа нь бичиг хэргийн ажилтан ажиллуулсантай холбоотой байна. Сувилагч Ж.Нямсүрэнд байгууллагын дотоод хяналтын багийн ажил, бага эмч С.Одончимэгт ёс зүйн багийн ажил, архив, бичгийн хэргийн ажилтан Б.Амаржаргалд нууцын ажлыг хавсруулж, нэмэгдэл олгож байна. Албан тушаалын тодорхойлолт байхгүй атлаа нэмэгдэл олгож байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", Засгийн газрын 2017 оны 246 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн болон албаны нууц хамгаалах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох журам"-ын 1.2, 2.1 дэх заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан орон тоогүй атлаа хавсран ажилласан нэмэгдэл цалин олгосон

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан орон тоонд багтаан ажиллах, нууц хамгаалах ажилтан болон бусад албан тушаалын нэмэгдлийг зогсоох

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.2.1 Илрүүлэлт:

Тайлант онд багаж техник худалдан авах зардлаас 14423.0 мянга, тавилга эд хогшил худалдан авах зардлаас 1400.0 мянга, бусад бараа үйлчилгээний зардлаас 4162.8 мянга,

эмийн зардлаас 1852.0 мянга, нийт 21837.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө авч, хөрөнгөд бүртгэсэн байна. Тайлант онд эмийн зардалд анх 21581.8 мянган төгрөг батлагдаж, аймгийн Засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар тус зардалд 7500.0 мянган төгрөг нэмж тодотгосон байхад төсвийн зориулалтын дагуу зарцуулалгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 4062.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авах тушаал гаргаагүй байна.

Энэ нь Хэмжилт, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, үндсэн хөрөнгө орлогод авах тушаал гаргаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөж, эмийн зардлаас хөрөнгө бэлтгэдэг явдлыг таслан зогсоож, төсвийг зориулалт бусаар зарцуулахгүй байх, байгууллагын даргын тушаалаар хөрөнгө бэлтгэсэн хөрөнгийг орлогод бүртгэж байх.

Батлагдсан

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Анхан шатны баримтыг тулган шалгахад гэрэл цахилгааны зардлаас шатахуун, цахилгаан хэрэгсэл худалдан авах, гагнуурын хөлс төлөх зэрэгт 711.0 мянган төгрөгийг төлж, төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Хэмжилт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг тус тус зөрчсөн байна.

3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх.

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг дагуу зардлыг бүртгэж, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.4 Батлагдсан төсөв, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Байгууллагын 2019 оны төсөвт анх 408497.4 мянган төгрөг баталж, аймгийн засаг даргын 2019.10.28-ны өдрийн А/560 тоот захирамжаар төсөвт зохицуулалт хийж, 14742.5 мянган

төгрөгийг нэмж тодотгон 423239.9 мянган төгрөг болсон байхад байгууллагад өгсөн төсвийн хуваарь, төсвийн төлөвлөлтийн программ дээр багаж, техник хэрэгсэл худалдан авах зардал дээр 10000.0 мянган төгрөг зарцуулах эрхийг тавьж өгсөн боловч аймгийн Засаг даргын төсөвт зохицуулалт хийх захирамжийг гаргахдаа тус дүнг дүнд оруулаагүй орхигдуулсантай холбоотой байна.

Энэ нь Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэснийг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Батлагдсан зардлыг хэтрүүлсэн байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийн хуваарийг тухай бүр нь албажуулж авч, мөрдөж ажиллаж байх.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

3.5. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.5 Зардлын данстай холбоотой асуудал

Тус байгууллага "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн Acolous программыг ашиглаж санхүүгийн тайланг бэлтгэсэн бөгөөд аудитад шаардлагатай файлуудыг бүрэн хөрвүүлж, тодруулга тайлангуудыг бүрэн бэлтгэсэн байна. Харин 2019 онд цалингийн Payroll программыг худалдан авч, төлбөр тооцоог хийгээгүй байгаа ба тус программыг ашиглаж цалин хөлсний тооцоог бодроогүй байна.

Энэ нь Үнэлгээ гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаалаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын НББ-ийн программд тавих шаардлага"-ын 3-т "Нягтлан бодох бүртгэлийн программд дараах модулыг иж бүрэн хамруулсан байна...цалин хөлсний бүртгэл" гэж заасныг зөрчсөн байна.

3.4.2 Эрсдэл:

Санхүүгийн программыг бүрэн ашиглаагүй байх

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Цалингийн Payroll программыг Acolous программтай уялдуулан ашиглаж, Төрийн аудитын байгууллагад дээрх программуудаас хөрвүүлж буй СТАУС файлыг иж бүрнээр нь ирүүлж байх

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Алдааг хүлээн зөвшөөрч байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор, нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,817,032.55	14,865,352.08
АВЛАГА	503,950.55	535,855.08
Ажиллагчидтай холбогдсон авлага	503,950.55	535,855.08
УРЬДЧИЛГАА	112,500.00	400,000.00
Урьдчилгаа тооцос	112,500.00	400,000.00
Цалингийн урьдчилгаа	112,500.00	400,000.00
БАРАА МАТЕРИАЛ	19,200,582.00	13,929,497.00
Түүхий эд материал	13,353,882.00	10,593,183.00
Тусгай зориулалттай материал	13,168,882.00	9,715,378.00
Эм боох материал	185,000.00	877,805.00
Бэлэн бүтээгдэхүүн	2,203,600.00	1,109,000.00
Хангамжийн материал	3,643,100.00	2,227,314.00
Бичиг хэргийн материал	195,000.00	162,000.00
Аж ахуйн материал	3,295,600.00	1,950,010.00
Түлш, шатах тослох материал	00.00	82,204.00
Хүнсний материал	152,500.00	33,100.00
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	366,251,268.61	367,397,077.41
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	366,251,268.61	367,397,077.41
Биет хөрөнгө	355,765,268.41	356,911,077.21
Барилга, байгууламж, орон сууц	285,841,456.00	285,841,456.00
Хуримтлагдсан элэгдэл	-16,171,217.65	-17,373,384.11
Авто-тээврийн хэрэгсэл	50,841,344.00	45,360,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-3,201,354.48	-5,560,010.44
Машин тоног төхөөрөмж (компьютер)	103,709,239.92	95,057,887.92
Хуримтлагдсан элэгдэл	-78,667,439.89	-65,363,945.87
Тавилга, аж ахуйн эд хогшил	22,948,440.00	24,438,155.00
Хуримтлагдсан элэгдэл	-10,080,699.49	-6,034,581.29
Ном	545,500.00	545,500.00
Биет бус хөрөнгө	10,486,000.20	10,486,000.20
Програм хангамж	650,000.00	650,000.00
Хуримтлагдсан элэгдэл	-649,999.80	-649,999.80
Бусад биет бус хөрөнгө	10,486,000.00	10,486,000.00
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	386,068,301.16	382,262,429.49
НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	19,479.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	19,479.00
Өглөг	00.00	19,479.00
Ажиллагчидтай холбогдсон өглөг	00.00	19,479.00
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	386,068,301.16	382,242,950.49
Засгийн газрын хувь оролцоо	386,068,301.16	382,242,950.49
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	326,681,036.00	326,681,036.00
Өмч: - төрийн	326,681,036.00	326,681,036.00
Хуримтлагдсан үр дүн	-72,395,681.48	-76,221,032.15
Өмнөх үеийн үр дүн	-72,395,681.48	-72,395,681.48
Тайлант үеийн үр дүн	00.00	-3,825,350.67
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	131,782,946.64	131,782,946.64
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	386,068,301.16	382,262,429.49

005

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	419,730,384.00	433,316,100.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37,224,506.00	185,000.00
Нийтлэг татварын бус орлого	37,224,506.00	185,000.00
Төсөв байгууллагын өөрийн орлого	37,224,506.00	185,000.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	37,224,506.00	185,000.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	60,725,078.00	53,267,000.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,730,800.00	379,864,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	40,243,240.00	79,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,243,240.00	79,100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	20,532,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	20,532,800.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,481,838.00	32,655,100.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,324,738.00	00.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	32,655,100.00
Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	15,157,100.00	00.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	405,332,215.55	436,925,460.81
УРСГАЛ ЗАРДАЛ	405,332,215.55	436,925,460.81
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	359,748,743.24	436,918,428.46
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,106,075.62	263,594,095.83
Үндсэн цалин	203,106,075.62	263,594,095.83
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,425,916.39	34,315,399.64
Тэтгэрийн даатгал	18,296,353.66	24,352,526.02
Тэтгэмжийн даатгал	1,902,265.24	2,288,193.58
ҮСМШӨ-ний даатгал	1,266,279.79	1,444,075.52
Ажилгүйдлийн даатгал	435,060.17	600,678.71
Эрүүл мэндийн даатгал	3,525,952.53	5,629,925.81
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,946,251.00	16,541,516.00
Гэрэл, цахилгаан	1,303,851.00	2,025,116.00
Түлш, халаалт	16,219,300.00	14,378,400.00
Цэвэр, бохир ус	423,100.00	138,000.00
Хангамж, бараа материалын зардал	26,398,211.00	28,433,462.00
Бичиг хэрэг	2,071,200.00	5,270,050.00
Тээвэр, шатахуун	22,389,911.00	21,284,556.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	607,200.00	1,815,000.00
Хөг хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,329,900.00	33,800.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	30,056.00
Нормативт зардал	34,986,194.69	37,870,644.65
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	27,385,910.69	26,285,644.65
Хоол, хүнс	5,949,684.00	8,276,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,650,600.00	3,309,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,391,000.00	1,152,700.00
Урсгал засвар	2,391,000.00	1,152,700.00
Томилолт, зочны зардал	948,000.00	1,820,000.00
Дотоод албан томилолт	948,000.00	1,820,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,760,956.00	8,578,145.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,748,556.00	8,578,145.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,400.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	37,786,138.54	44,612,465.34
Бараа үйлчилгээний бусад зардал	12,017,925.00	24,136,464.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,768,213.54	20,476,001.34

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,583,472.31	7,032.35
Бусад урсгал шилжүүлэг	45,528,278.00	00.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,324,738.00	00.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,203,540.00	00.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,418.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,418.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,194.31	3,614.35
Төвлөрүүлэх шилжүүлэг	55,194.31	3,614.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	14,398,168.45	-3,609,360.81
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	13,471,363.44	215,989.86
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	215,989.86
Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	13,471,363.44	00.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-13,471,363.44	-215,989.86
НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	926,805.01	-3,825,350.67

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	382,505,878.00	433,131,100.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	382,505,878.00	433,131,100.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,780,800.00	379,864,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	40,243,240.00	79,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,243,240.00	79,100.00
Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	20,532,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллагаг/	00.00	20,532,800.00
Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,481,838.00	32,655,100.00
Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,324,738.00	00.00
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	32,655,100.00
Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	15,157,100.00	00.00
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	370,374,878.00	411,293,300.00
УРСГАЛ ЗАРДАЛ	370,374,878.00	411,293,300.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,301,705.69	411,286,267.65
Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	195,954,087.00	260,711,900.00
Үндсэн цалин	149,464,956.00	195,628,200.00
Нэмэгдэл	33,165,104.00	51,019,500.00
Урамшуулал	13,324,027.00	14,064,200.00
Ажил олгогчдоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,932,100.00	33,882,800.00
Тэтгэврийн даатгал	15,954,700.00	23,527,500.00
Тэтгэмжийн даатгал	1,994,300.00	2,588,800.00
ҮОМШӨ-ний даатгал	1,595,500.00	2,071,100.00
Ажилгүйдлийн даатгал	398,900.00	517,800.00
Эрүүл мэндийн даатгал	3,988,700.00	5,177,600.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,888,001.00	17,529,382.00
Гэрэл, цахилгаан	1,595,851.00	2,729,862.00
Түлш, халаалт	17,349,950.00	14,399,520.00
Цэвэр, бохир ус	942,200.00	400,000.00
Хангамж, бараа материалын зардал	18,773,701.00	21,979,240.00
Бичиг хэрэг	979,200.00	1,199,500.00

**Бөмбөгөр сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Тээвэр, шатахуун	15,682,501.00	16,765,100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	2,015,000.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,200.00	1,999,640.00
Нормативт зардал	30,327,037.69	38,763,105.65
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,319,107.69	27,048,505.65
Хоол, хүнс	5,999,930.00	7,699,600.00
Нормын хувцас, зөөлөн өднэл	3,008,000.00	4,015,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,651,000.00	3,000,000.00
Багаж, техник, хэрэгсэл	52,000.00	00.00
Урсгал засвар	2,599,000.00	3,000,000.00
Томилонт, зочны зардал	948,000.00	1,820,000.00
Дотоод өлбөн томилонт	948,000.00	1,820,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,825,521.00	14,879,106.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,677,021.00	14,479,106.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	8,002,258.00	18,720,734.00
Бараа үйлчилгээний бусад зардал	8,002,258.00	18,720,734.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,073,172.31	7,032.35
Бусад урсгал шилжүүлэг	49,017,978.00	00.00
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,324,758.00	00.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,450,000.00	00.00
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	40,243,240.00	00.00
Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	3,418.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,418.00
Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,194.31	3,614.35
Төвлөрүүлэх шилжүүлэг	55,194.31	3,614.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	12,131,000.00	21,837,800.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	12,131,000.00	21,837,800.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,131,000.00	21,837,800.00
Дотоод эх үүсвэрээр	12,131,000.00	21,837,800.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,131,000.00	21,837,800.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(4)-(5)	-12,131,000.00	-21,837,800.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	316,195,036.00	00.00	-73,322,486.49	242,872,549.51
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	316,195,036.00	00.00	-73,322,486.49	242,872,549.51
Тайлант үеийн үр дүн	10,486,000.00	00.00	926,805.01	11,412,805.01
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	-72,395,681.48	386,068,301.16
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	-72,395,681.48	386,068,301.16
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	-72,395,681.48	386,068,301.16
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-3,825,350.67	-3,825,350.67
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	326,681,036.00	131,782,946.64	-76,221,032.15	382,242,950.49

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	321,780,800.00	321,725,705.69	433,239,900.00	433,044,967.65
УРСГАЛ ЗАРДАЛ	321,780,800.00	321,725,705.69	433,239,900.00	433,044,967.65
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,780,800.00	318,275,705.69	433,239,900.00	433,044,967.65
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	199,434,000.00	195,954,087.00	260,711,900.00	260,711,900.00
Үндсэн цалин	149,494,800.00	149,464,956.00	195,628,200.00	195,628,200.00
Нэмэгдэл	34,578,100.00	33,165,104.00	51,019,500.00	51,019,500.00
Урамшуулал	15,361,100.00	13,324,027.00	14,064,200.00	14,064,200.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,932,100.00	23,932,100.00	33,882,800.00	33,882,800.00
Тэтгэврийн даатгал	15,954,700.00	15,954,700.00	23,527,500.00	23,527,500.00
Тэтгэмжийн даатгал	1,994,300.00	1,994,300.00	2,588,800.00	2,588,800.00
ҮОМЦӨ-ний даатгал	1,595,500.00	1,595,500.00	2,071,100.00	2,071,100.00
Ажилгүйдлийн даатгал	398,900.00	398,900.00	517,800.00	517,800.00
Эрүүл мэндийн даатгал	3,988,700.00	3,988,700.00	5,177,600.00	5,177,600.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,890,500.00	19,888,001.00	17,532,800.00	17,529,382.00
Гэрэл, цахилгаан	1,596,500.00	1,595,851.00	2,732,800.00	2,729,862.00
Түлш, халаалт	17,350,000.00	17,349,950.00	14,400,000.00	14,399,520.00
Цэвэр, бохир ус	944,000.00	942,200.00	400,000.00	400,000.00
Хангамж, бараа материалын зардал	18,774,700.00	18,773,701.00	21,981,100.00	21,979,240.00
Бичиг хэрэг	980,000.00	979,200.00	1,200,000.00	1,199,500.00
Тээвэр, цаатахуун	15,682,500.00	15,682,501.00	16,765,100.00	16,765,100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	712,800.00	2,016,000.00	2,015,000.00

Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,400.00	1,399,200.00	2,000,000.00	1,999,640.00
Нормативт зардал	30,335,800.00	30,327,037.69	40,797,700.00	40,615,105.65
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	21,319,900.00	21,319,107.69	29,081,800.00	28,900,505.65
Хоол, хүнс	6,000,000.00	5,999,930.00	7,700,000.00	7,699,600.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,015,900.00	3,008,000.00	4,015,900.00	4,015,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	4,200,000.00	4,191,000.00	18,825,000.00	18,823,000.00
Багаж, техник, хэрэгсэл	1,600,000.00	1,592,000.00	14,425,000.00	14,423,000.00
Тавилга	00.00	00.00	1,400,000.00	1,400,000.00
Урсгал засвар	2,600,000.00	2,599,000.00	3,000,000.00	3,000,000.00
Томилолт, зочны зардал	950,000.00	948,000.00	1,820,000.00	1,820,000.00
Дотоод албан томилолт	950,000.00	948,000.00	1,820,000.00	1,820,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,510,500.00	15,509,521.00	17,156,300.00	17,152,806.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,362,000.00	15,361,021.00	16,756,300.00	16,752,806.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	400,000.00	400,000.00
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	148,500.00	148,500.00	00.00	00.00
Бараа үйлчилгээний бусад зардал	8753200.00	8752258.00	20532300.00	20530734.00
Бараа үйлчилгээний бусад зардал	8,753,200.00	8,752,258.00	20,532,300.00	20,530,734.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	3450000.00	0.00	0.00
Бусад урсгал шилжүүлэг	00.00	3,450,000.00	00.00	00.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	3,450,000.00	00.00	00.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	321,780,800.00	321,725,705.69	433,239,900.00	433,044,967.65
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	321,780,800.00	321,725,705.69	379,864,100.00	379,860,534.00
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	321,780,800.00	321,725,705.69	379,864,100.00	379,860,534.00
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	20,532,800.00	20,529,382.00
Орон нутгийн төсвөөс	00.00	00.00	20,532,800.00	20,529,382.00
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	00.00	00.00	32,843,000.00	32,655,051.65
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	00.00	32,843,000.00	32,655,051.65
АЖИЛЛАГСАДЫН ТОО	23.00	23.00	23.00	23.00
Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
Гүйцэтгэх ажилтан	17.00	17.00	17.00	17.00
Үйлчлэх ажилтан	05.00	05.00	05.00	05.00

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	79,100.00
УРСГАЛ ЗАРДАЛ	79,100.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	79,100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	79,100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	79,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	79,100.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	79,100.00

Бэлтгэсэн:

АХЛАХ АУДИТОР




Б.ДОЛЖМАА

Огноо: 2020.02.27

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР




А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.02.27

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

Огноо: 2020.02.27